



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 сарын 05 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.15 дахь заалтад доор дурдсан агуулгатай дараах дэд заалт нэмсүгэй:

“-үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.14 дэх заалтын “-аж үйлдвэрийн паркийн асуудал” гэснийг “-үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР